

ТАНИЛЦУУЛГА

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-д эдийн засгийн өсөлтийг 6 хувьд хадгалж, нэг хүнд ногдох үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэнэ гэж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д заасан “Татварын шинэчлэл”-ийн хүрээнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын орчныг олон улсын стандартад нийцүүлж, цахим тогтолцоог сайжруулах, бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх зэрэг зорилтуудыг тус тус тусгасан.

Дээрх бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, орлогын татварын орчныг татварын тогтолцооны шударга байх зарчимтай нийцүүлэх, олон улсын нийтлэг жишгээр боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийг хөдөлмөр эрхэлж, баялаг бүтээж буй иргэдэд чиглүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа. Хуулийн төсөлд дараах үндсэн чиглэлийг баримталж, холбогдох зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэг. Татварын хөнгөлөлтийн бодлогыг оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулна.

Сүүлийн жилүүдэд геополитикийн тогтворгүй нөхцөл байдлаас үүдэн эдийн засгийн өсөлт удаашрах, инфляцын түвшин зорилтот түвшин хүртэл буурахгүй байх эрсдэлүүд үргэлжилж байна. Олон улсад иргэдийн амьжиргааг дэмжих зорилгоор тодорхой түвшнээс бага орлого олсон тохиолдолд татварын хөнгөлөлт хэлбэрээр буцаан олгох арга хэмжээг авч хэрэгжүүлдэг нийтлэг жишигтэй.

Иймд одоогийн хуулийн хүрээнд хэрэгжиж буй хөнгөлөлтийн бодлогыг орлогын хэмжээнээс үл хамааран бүх иргэдэд эдлүүлэх, үйл ажиллагааны орлоготой иргэдийг хамруулах, хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэх, мөн сургалтын төлбөртэй тэнцэх хэмжээний орлогод үзүүлдэг албан татварын хөнгөлөлтийг босготой болгох зэрэг зохицуулалтуудыг тусгаж, хөнгөлөлтийн бодлогыг оновчтой, хүртээмжтэй болгох замаар нийт иргэдийн дундаж татварын ачааллыг бууруулна.

Хоёр. Шаталсан татварын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгоно.

Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т татварын үйл ажиллагаанд “шударга байх” зарчмыг баримтална гэж заасан нь татвар төлөгчийн орлогын хэмжээнээс хамаарч төлөх татварыг ялгаатай тогтоох агуулгыг илэрхийлдэг. Энэ хүрээнд дэлхийн 170 гаруй улс шаталсан татварын тогтолцоог хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ өсөлтийн үр өгөөжийг нийт хүн амд хүртээмжтэй байлгах, орлогын тэгш бус байдлыг бууруулахад чиглүүлдэг.

Иймд шаталсан татварын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох хүрээнд үйл ажиллагааны орлогыг шатлалд хамруулах, шаталсан татвар ногдуулах босго дүнг нэмэгдүүлэх, гурван шатлалыг өргөтгөж шатлал хоорондын хувь хэмжээг бууруулах, бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлогыг үйл ажиллагааны орлогод хамааруулан хялбаршуулсан горимоор тайлагнан 1 хувиар татвар төлөх босгыг 400 сая төгрөг болгох зэрэг зохицуулалтыг тусгах замаар бүх нийтээрээ жигд, шударга төлөх татварын орчныг бүрдүүлнэ.

Гурав. Татварын тайланг цахимаар урьдчилан боловсруулж, хүргүүлэн татвар төлөгчийн төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулна.

Монгол Улсын татварын албаны цахимжилт хурдацтай хөгжиж байгаа ч хувь хүн өөрийн орлого, хасагдах зардлаа тодорхойлох, тайлагнахад хүндрэлтэй байгаа нь татварын тайланг алдаатай гаргах, хугацаандаа хүргүүлэхгүй байх, тайлагнахгүй байх зэрэг эрсдэлийг дагуулж байна. Харин дэлхий нийтийн жишгээр татварын үйл ажиллагаа хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан, хүний оролцоо багатай, бүрэн цахимжсан системд шилжиж, дараагийн түвшинд гарч байна.

Иймд иргэдийн тайлагнал, төлөлтийн үйл ажиллагааг хялбаршуулах, татварын эрсдэлийг бууруулах зорилгоор татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан хүргүүлдэг хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан үйлчилгээг нэвтрүүлж, татвар төлөгчид тайлангийн төслийг залруулах, хувийн хэрэглээндээ гэж бүртгүүлсэн төлбөрийн баримтыг хасагдах зардалд шилжүүлж бүртгүүлэх, тайлан баталгаажуулах болон татвар төлөх хугацааг сунгаж, уян хатан болгоно.

Дөрөв. Ногоон орон сууцжуулалтыг татварын бодлогоор дэмжиж, бүсийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ногоон орон сууцжуулалтыг бодлогоор дэмжих, бүсийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн орон нутгийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэхээр тусгасан. Энэ хүрээнд олон улсад түгээмэл хэрэгждэг ногоон орон сууцны татварын дэмжлэгийг орон нутгийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд анх удаа орон сууц худалдан авахад үзүүлдэг татварын хөнгөлөлтийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж, төвлөрлийг сааруулах, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, гэр хорооллын дулаан алдагдлыг бууруулах сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг дэмжихэд чиглүүлж, хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэхээр хуулийн төсөлд тусгалаа.

Ийнхүү хуулийн төсөл батлагдсанаар нийт иргэдийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг нэмэгдүүлэн урт хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн зэрэгцээ татварын хамрагдалт, бааз суурь тэлж, далд эдийн засаг буурах мөн бүс орон нутаг бие даасан, өрсөлдөхүйц, ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх, татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой зардал буурах зэрэг эерэг үр дагавартай байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй хамт Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод эдийн засаг нь өрх, иргэн бүрд тэгш, хүртээмжтэй хүрсэн байх эрхэм зорилгыг дэвшүүлэн “Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин өрхийн орлогыг тогтвортой нэмэгдүүлж, дундаж давхаргыг бүрдүүлнэ”, “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, “Хүн амын худалдан авах чадварт нийцсэн, ногоон шийдэл бүхий чанартай орон сууцны хүрэлцээ, хангамжийг сайжруулна”, “Цахим засаглалын технологийг бүх түвшинд бүрэн хэрэгжүүлж, авлига хүнд сурталгүй төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” дунд хугацааны зорилтот хөтөлбөрт урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг дунджаар 6 хувьд хадгалж, нэг хүнд ногдох үндэсний орлогыг 2 дахин нэмэгдүүлж, ажиллах хүчний оролцооны түвшнийг 65 хувьд хүргэнэ гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.1-д “Татвар, нийгмийн даатгалын шинэчлэл хийх”-ээр заасан бөгөөд энэ хүрээнд бага, дунд орлоготой иргэдийн татварын ачааллыг бууруулах, татварын суурь тогтолцооны тогтвортой байдлыг хангах, татварын орчныг олон улсын стандартад үе шаттайгаар нийцүүлж, цахим татварын тогтолцоог сайжруулах, татварын дэмжлэгүүдийг оновчтой болгож, хариуцлагатай татвар төлөгчдийг дэмжих, Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах хүрээнд бүсийн ялгаатай татварын тогтолцоог бүрдүүлэх зорилтуудыг тус тус тусгасан.

Татварын багц хуулийн шинэчлэлийн хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 онд Улсын Их Хурлаас баталж, 2020 оноос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэхүү шинэчлэл нь бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого олж буй хувь хүн болон хувиараа бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний татвар төлөхтэй холбогдох зардлыг бууруулах, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах үндсэн зорилготой байсан.

Хуулийн шинэчлэлээс хойших хугацаанд геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляцын түвшин өсөх зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвт бий болоод байна.

Монгол Улсын хувьд инфляцын түвшин нэмэгдэж, 2025 оны 02 дугаар улирлын байдлаар 8.2 хувьд хүрсэн ба энэ нь голчлон бага дунд орлоготой иргэн, өрхийн амьжиргаанд сөргөөр нөлөөлж, тэдний бодит орлого, худалдан авах чадварыг бууруулж байна.

Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт татвар тогтоох, ногдуулах, тайлагнах, төлөх, хөнгөлөх, чөлөөлөх үйл ажиллагаанд татварын эдийн засгийн гол зарчим болох шударга байх зарчмыг баримтална гэж заасан байдаг. Тус

зарчим нь татвар төлөгчийн орлогын хэмжээнээс хамаарч төлбөл зохих татварыг ялгаатай тогтоох агуулгыг илэрхийлэх бөгөөд энэхүү зарчмыг шаталсан татварын тогтолцоогоор хэрэгжүүлдэг нийтлэг жишигтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 05 дугаар дүгнэлтэд “Татварын ачааллыг тэгш, шударгаар хуваарилж, татвар төлөгчийн орлогын хэмжээ, төлөх чадавхад нийцсэн хувь хэмжээгээр татвар ногдуулах нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шударга ёсны зарчимд нийцнэ.”, “Орлого өндөр байхын хэрээр татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх нь орлогын ялгааг багасгаж, хуваарилалтыг тэнцвэржүүлэх, татвар төлөх чадавхтай нь уялдуулан татварын ачааллыг шударга хуваарилах, баялгийн хэт төвлөрөлтөөс сэргийлэх, бага орлоготой иргэдийн татварын ачааллыг багасгах, эдийн засгийн өсөлтийн тэнцвэрийг хангах зэрэг эерэг үр нөлөөтэй байна.” гэж тус тус тусгагджээ.

Энэ хүрээнд дэлхийн 170 гаруй улс орон орлогын хэмжээнээс хамаарсан шаталсан татварын тогтолцоог хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ өсөлтийн үр өгөөжийг нийт хүн амд хүртээмжтэй байлгах, нийгмийн баялгийг үр дүнтэй хуваарилах, орлогын тэгш бус байдлыг бууруулах үндсэн зорилготой байдаг. Цаашлаад хувь хүний орлогын албан татварын бодлогоор бага дунд орлоготой иргэн, өрхөд татварын дэмжлэг үзүүлж, тэдний татварын дараах орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь олон улсад түгээмэл жишиг байдаг. Тухайлбал сүүлийн жилүүдэд Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Франц Улс, Бүгд Найрамдах Сингапур Улс зэрэг улсууд иргэдийн орлогыг хамгаалах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох зорилгоор хөдөлмөр эрхэлж буй иргэдийн орлогод болон тэдний худалдан авсан ногоон орон сууцанд албан татварын хөнгөлөлтийг буцаан олголтоор эдлүүлж, иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулах, байгаль орчинд ээлтэй хэрэглээг дэмжих бодлогыг баримталж байна.

Улмаар хурдацтай өөрчлөгдөж буй дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, дотоодын нийгэм эдийн засгийн сорилтуудыг харгалзан өнөөгийн хувь хүний орлогын албан татварын орчныг татварын тогтолцооны шударга байх зарчимтай нийцүүлэх, олон улсын нийтлэг жишгээр боловсронгуй болгох, орлогын тэгш бус байдлыг бууруулах зорилттой уялдуулан эдийн засгийн өсөлтийг хөдөлмөр эрхэлж, баялаг бүтээж буй иргэдэд чиглүүлэх шаардлага бий болж байна.

Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй орон сууц шинээр барих, засварлахад дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж, бүсийн хөгжлийн бодлоготой нийцүүлэн орон нутгийн ялгаатай татварын бодлого хэрэгжүүлнэ гэж тусгасны дагуу хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, хөдөө орон нутгаас Улаанбаатар хотыг чиглэсэн шилжилт хөдөлгөөнийг бууруулах, мөн нийслэл хотоос орон нутагт шилжин суух иргэдийн амьдрах таатай орчныг бүрдүүлэх, цаашлаад эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй, ногоон барилгыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ үүсээд байна.

Цаашлаад, Монгол Улсын татварын албаны цахимжилт эрчимтэй хөгжиж, татвар төлөгчийн тайлагналтад хүний оролцоо бага байх нөхцөл бүрдсэн хэдий ч хувь хүн өөрийн орлого, хасагдах зардал, татвар ногдуулах орлогыг тодорхойлох, тайлагнахад хүндрэлтэй байгаа нь татварын тайланг алдаатай гаргах, хугацаандаа хүргүүлэхгүй байх, огт тайлагнахгүй байх зэрэг эрсдэлийг дагуулж байна. Дэлхий

нийтэд эдийн засаг, бизнесийн харилцаа өргөжин тэлж, техник, технологийн хөгжил хурдацтай өрнөхийн хэрээр татварын үйл ажиллагаа дараагийн түвшинд гарч, хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан, хүний оролцоо багатай, бүрэн цахимжсан системд шилжиж байна. Ийнхүү татвар төлөгчийн тайлагнал, төлөлтийн үйл ажиллагааг хялбаршуулах, татварын эрсдэлийг бууруулах зорилгоор Монгол Улсын татварын алба тайлангийн төслийг урьдчилан бэлтгэн хүргэх, цахим системээр татварын эрсдэлийг автоматаар үнэлэх, эрсдэлтэй татвар төлөгчдөд урьдчилан анхааруулга, сануулга өгөх, мэдээлэлд суурилсан шийдвэр гаргадаг тогтолцоонд үе шаттай шилжих шаардлагатай байна.

Татварын хууль тогтоомжуудад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах зорилгоор Сангийн яам, татвар, гаалийн байгууллага, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим болон Улсын Их Хурлын Тамгын газар хамтран улс орон даяар давхардсан тоогоор 11,000 гаруй татвар төлөгчийг хамруулсан 150 удаагийн уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, 176 мянга орчим саналыг хүлээн авсан. Хэлэлцүүлгийн явцад нийтлэг байдлаар ирүүлсэн иргэдийн татварын ачааллыг бууруулах, бүх нийтээрээ жигд, шударга төлдөг татварын эрх зүйн орчныг бүрдүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг боловсронгуй болгох, татвар төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулах зэрэг саналуудыг хуулийн төсөлд тусгах нь зүйтэй байна.

Дээрх бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэх, орлогын татварын орчныг татварын тогтолцооны шударга байх зарчимтай нийцүүлэх, олон улсын нийтлэг жишгээр боловсронгуй болгох, эдийн засгийн өсөлтийг хөдөлмөр эрхэлж, баялаг бүтээж буй иргэдэд чиглүүлэх зорилгоор Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөлд үзэл баримтлалд тусгасан үндсэн чиглэлийг баримталж, дараах холбогдох зохицуулалтыг тусгасан. Үүнд:

Нэг. Татварын хөнгөлөлтийн бодлогыг оновчтой, хүртээмжтэй болгох замаар иргэн, өрхийн татварын ачааллыг бууруулна.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлд татварын хөнгөлөлтийг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох зохицуулалтыг тусгалаа.

Тодруулбал одоогийн хуулиар зөвхөн жилийн 36 сая төгрөг хүртэлх цалингийн орлоготой иргэдэд үзүүлдэг 240 мянга хүртэлх төгрөгийн шаталсан хөнгөлөлтийг орлогын хэмжээнээс үл хамааран бүх иргэдэд эдлүүлэх, үйл ажиллагааны орлоготой иргэдийг хамруулах, хөнгөлөлтийн хэмжээг нэмэгдүүлэх мөн сургалтын төлбөртэй тэнцэх хэмжээний орлогод үзүүлдэг албан татварын хөнгөлөлтийг босготой болгох зэрэг болно.

Ингэснээр хөдөлмөр эрхэлж буй бүх иргэн сарын 800 мянган төгрөг хүртэлх орлогодоо 100 хувь орлогын татвараас хөнгөлүүлж, тухайн жилийн татварын тайлангаа тооцож баталгаажуулсны үндсэнд буцаан авснаар нийт иргэдийн дундаж татварын ачаалал 0-5 хувь болж буурах юм.

Хоёр. Шаталсан татварын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох замаар бүх нийтээрээ жигд, шударга төлдөг татварын орчныг бүрдүүлнэ.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлд татварын тогтолцооны суурь зарчим болох шударга байх зарчмыг баримтлан холбогдох зохицуулалтуудыг тусгалаа.

Тодруулбал шаталсан татварын тогтолцоог эдийн засгийн өсөлт, олон улсын жишигт нийцүүлэн үе шаттайгаар боловсронгуй болгох хүрээнд үйл ажиллагааны орлогыг шатлалд хамруулах, одоогийн 20 хувийн татвар ногдуулах орлогын сарын 15 сая төгрөгийн босгыг 2 дахин нэмэгдүүлж 30 сая төгрөг хүргэх, улмаар гурван шатлалтай хувь хэмжээг зургаан шатлал болгон өргөтгөж шатлал хоорондын хувь хэмжээг бууруулах өөрчлөлтүүдийг тусгаж, бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлогыг үйл ажиллагааны орлогод хамааруулж, хялбаршуулсан горимоор тайлагнан орлогын 1 хувиар татвар төлөх босго дүнг 400 сая төгрөг болгож өөрчлөх зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар шатлалд хамрагдаж буй иргэдийн татварын ачаалал буурч, бүх нийтээрээ жигд, шударга төлдөг татварын орчин бүрдэх юм.

Гурав. Татварын тайланг цахимаар урьдчилан боловсруулж, хүргүүлэн татвар төлөгчийн төлөх, тайлагнах үйл ажиллагааг хялбаршуулж, уян хатан болгоно.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл, 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 5 дугаар зүйл болон 6 дугаар зүйлд татвар төлөгчийг үүсэж болзошгүй татварын эрсдэлээс урьдчилсан сэргийлэх зорилгоор татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан бэлтгэн хүргүүлдэг зохицуулалтыг тусгалаа.

Тодруулбал татварын албанаас тайлангийн төслийг урьдчилан бэлтгэн хүргүүлдэг хиймэл оюун ухаан, их өгөгдөлд суурилсан үйлчилгээг нэвтрүүлж, татвар төлөгчид тайлангийн төслийг залруулах, хувийн хэрэглээндээ гэж бүртгүүлсэн төлбөрийн баримтыг үйл ажиллагааны орлогоос хасагдах зардалд шилжүүлж бүртгүүлэх, тайлан баталгаажуулах болон татвар төлөх хугацааг сунгаж, уян хатан болгох зэрэг болно.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэдийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой зардал буурах эерэг үр дагавартай.

Дөрөв. Эрчим хүчний хэмнэлттэй, ногоон орон сууцжуулалтыг татварын бодлогоор дэмжиж, бүс, орон нутаг хүн ам, ажиллах хүч татах ялгаатай татварын бодлогыг бие даан хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйл, 6 дугаар зүйлд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, эрчим хүчний хэмнэлттэй, хүртээмжтэй, ногоон барилгыг нэмэгдүүлэхэд татварын бодлогоор дэмжих зохицуулалтыг тусгалаа.

Тодруулбал амьдран суух зориулалтаар анх удаа орон сууц худалдан авахад үзүүлдэг 6 сая хүртэлх төгрөгийн хөнгөлөлтийг бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулж, төвлөрлийг сааруулах, эрчим хүчний хэмнэлттэй, ногоон барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, гэр хорооллын дулаан алдагдлыг бууруулах сэргээгдэх

эрчим хүчний тоног төхөөрөмжийн хэрэглээг дэмжихэд чиглүүлж, хөнгөлөлтийн хэмжээг 15 сая төгрөг хүртэл болгон нэмэгдүүлэхээр өөрчлөх юм.

Ийнхүү Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар нийт иргэдийн татварын ачааллыг бууруулж, бодит орлогыг нэмэгдүүлэн урт хугацаандаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжихийн зэрэгцээ татварын хамрагдалт, бааз суурь тэлж, далд эдийн засаг буурах мөн бүс орон нутаг бие даасан, өрсөлдөхүйц, ялгаатай татварын бодлого хэрэгжүүлэх, татвар төлөгчдийн татварын хууль тогтоомжийг дагаж мөрдөхтэй холбоотой зардал буурах зэрэг эерэг үр дагавартай байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэх бөгөөд хуулийн төсөлтэй хамт Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

---oOo---

INTRODUCTION

On Draft Law to Amend the Personal Income Tax Law

By Resolution No. 52 of 2020, the State Great Khural approved the long-term development policy “Vision-2050,” which set forth the national goal of ensuring that the economy is equally and inclusively accessible to every household and citizen. The policy establishes objectives to: “Support employment and ensure stable growth of household income, while fostering the middle class”; “Reduce inequality across all sectors of society, increase the number of middle-income citizens, and improve quality of life”; “Enhance the supply and accessibility of quality housing with green solutions in line with citizens’ purchasing power”; and “Fully implement e-governance technology at all levels to establish public services free from corruption and bureaucracy.”

By Resolution No. 106 of 2021, the State Great Khural approved the medium-term program “New Recovery Policy,” which stipulates maintaining an average economic growth rate of 6 percent over the long term, doubling per capita national income, and increasing labor force participation to 65 percent.

By Resolution No. 21 of 2024, the State Great Khural approved the Government Action Program for 2024–2028, which under Paragraph 3.2.1 mandates “Tax and social insurance reforms.” Within this framework, the Program sets objectives to reduce the tax burden on low- and middle-income citizens; ensure stability of the tax base system; gradually align the tax environment with international standards; improve the digital tax system; optimize tax incentives; support responsible taxpayers; and establish differentiated regional tax systems to reduce urban concentration in Ulaanbaatar.

As part of the comprehensive tax law reform, the revised version of the Personal Income Tax Law was adopted by the State Great Khural in 2019 and entered into force in 2020. The main purpose of this reform was to support individuals engaged in small-scale trade, work, and services, as well as self-employed entrepreneurs, by reducing their compliance costs and simplifying reporting obligations.

Since then, global geopolitical instability, uncertainties in trade policy, slowing growth in major economies, and rising inflation have posed significant risks to the world economy.

For Mongolia, inflation has increased, reaching 8.2 percent as of the second quarter of 2025. This has particularly affected low- and middle-income households by reducing their real income and purchasing power.

Article 5.1 of the General Tax Law stipulates that the principle of fairness—an economic cornerstone of taxation—shall be observed in establishing, imposing, reporting, paying, exempting, and relieving taxes. This principle entails imposing different tax liabilities depending on a taxpayer’s income level, which is generally implemented through progressive tax systems.

In its Decision No. 05 of 16 May 2025, the Constitutional Court of Mongolia stated: “Equitably and fairly distributing tax burdens and imposing taxes in proportion to a

taxpayer's income and ability to pay conforms to the principle of justice under Article 1.2 of the Constitution.” The Court further noted: “Increasing tax rates as income rises has positive effects, such as reducing income disparities, ensuring equitable distribution, allocating tax burdens fairly in line with ability to pay, preventing excessive concentration of wealth, reducing the tax burden of low-income citizens, and maintaining economic balance.”

Accordingly, more than 170 countries worldwide implement progressive income tax systems aimed at supporting economic growth while ensuring inclusive distribution of its benefits, promoting equitable allocation of social wealth, and reducing inequality. Moreover, many jurisdictions use personal income tax policies to support low- and middle-income households by increasing their post-tax income. For example, in recent years, the Republic of Korea, the French Republic, and the Republic of Singapore have adopted policies to protect citizens' incomes, promote employment, and encourage energy efficiency by providing tax relief—often through refundable credits—on earned income and on green housing purchases, thereby reducing household tax burdens and promoting environmentally friendly consumption.

Given the rapidly changing global economy and Mongolia's domestic socio-economic challenges, it has become necessary to align the current personal income tax framework with the principle of fairness, refine it in accordance with international practices, reduce income inequality, and direct economic growth toward citizens engaged in work and wealth creation.

Furthermore, under the Government Action Program for 2024–2028, provisions are made to establish the legal framework for supporting the construction and renovation of energy-efficient, environmentally friendly housing, and to implement regionally differentiated tax policies consistent with regional development strategies. This is essential to ensure balanced urban–rural development, reduce migration flows from rural areas to Ulaanbaatar, improve living conditions for citizens relocating to the provinces, and increase the supply of affordable, green, and energy-efficient buildings.

Although Mongolia's tax administration has advanced rapidly in digitalization, reducing human involvement in taxpayer reporting, individuals still face challenges in determining income, deductible expenses, and taxable amounts. This leads to risks such as filing inaccurate returns, submitting late, or failing to file at all. Globally, as economic and business relations expand and technology evolves, tax systems are moving toward fully digitalized platforms with minimal human involvement, relying on artificial intelligence and big data. In order to simplify taxpayers' reporting and payments and reduce compliance risks, the Mongolian Tax Administration must gradually transition to systems that pre-fill tax returns, automatically assess risk, provide early warnings to high-risk taxpayers, and enable data-driven decision-making.

To introduce necessary legislative amendments, the Ministry of Finance, together with the tax and customs administrations, the National Chamber of Commerce and Industry, and the Secretariat of the State Great Khural, organized 150 consultations nationwide, engaging more than 11,000 taxpayers, and collected approximately 176,000 comments. During these consultations, common proposals included reducing citizens' tax burdens, establishing a fair and equitable tax environment, refining tax incentives

and exemptions, and simplifying tax payment and reporting obligations—all of which should be reflected in the draft law.

In line with these policies and objectives, and to align the personal income tax framework with the principle of fairness, refine it in accordance with international practice, and direct economic growth toward working citizens, the draft law on amendments to the Personal Income Tax Law has been prepared.

The draft law, based on the main directions outlined in the concept note, includes the following key provisions:

1.Reduce household tax burdens by optimizing and expanding the accessibility of tax relief.

Articles 3–6 of the draft law introduce provisions to refine tax relief in line with international standards. The current staggered relief of up to MNT 240,000 available only to wage earners with annual income of up to MNT 36 million will be extended to all citizens regardless of income, including those with business income. Moreover, the relief amount will be increased and the tuition-related deduction will be subject to a cap.

As a result, all employed citizens will receive full income tax relief on monthly income up to MNT 800,000, which they will reclaim after filing and confirming their annual return. Consequently, the average tax burden of citizens will decrease to 0–5 percent.

2. Establish a fair and equitable tax environment by refining the progressive tax system in line with international practice.

Articles 1 and 3–6 of the draft law provide for adjustments based on the principle of fairness, the foundation of the tax system. Specifically, business income will be subject to progressive brackets. The current threshold for the 20 percent rate, MNT 15 million monthly income, will be doubled to MNT 30 million. The number of tax brackets will be expanded from three to six, with reduced rates between brackets. Income from small-scale trade, work, and services will be reclassified as business income, with simplified reporting under a 1 percent tax rate threshold increased to MNT 400 million. As a result, taxpayers subject to progressive brackets will experience a reduced tax burden, while fostering a fairer, more equitable tax environment.

3. Simplify and streamline tax compliance by introducing pre-filled electronic returns.

Articles 2–6 of the draft law provide for the Tax Administration to prepare and deliver pre-filled returns, supported by artificial intelligence and big-data systems. Taxpayers will be able to review and correct pre-filled returns, reclassify receipts initially registered as “personal” into deductible business expenses, confirm returns and extend deadlines for submission and payment flexibly. This will reduce taxpayers’ compliance costs and associated risks.

4. Promote energy-efficient, green housing and enable independent implementation of regionally differentiated tax policies.

Articles 3, 4, and 6 of the draft law align with the Government Action Program and regional development policies, introducing provisions to support energy-efficient, affordable, and green housing through tax policy. Specifically, the current MNT 6 million deduction for first-time home purchases will be increased to MNT 15 million. This relief will be linked to regional development goals, reducing urban concentration, increasing supply of energy-efficient and green housing, and promoting renewable energy solutions to reduce heat loss in ger areas.

Adoption of the draft law on amendments to the Personal Income Tax Law will reduce citizens' tax burdens, increase real income, and support employment in the long term, while also expanding the tax base, reducing the shadow economy, enabling differentiated regional tax policies, and lowering taxpayers' compliance costs.

The draft law is consistent with the Constitution of Mongolia, Mongolia's international treaties, and other applicable legislation, and will be accompanied by corresponding amendments to the Budget Law.